



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Гочоогийн ГАНБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-23-35, Факс: 32-70-16
E-mail: ganboldg@parliament.mn
http://www.parliament.mn

2024.05.17 № УИХ-03/3489

танай _____-ны № _____-т


Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Г.ГАНБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

Ц.ИДЭРБАТ

Н.НАРАНБААТАР

Т.ЭНХТҮВШИН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ГАНБОЛД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.22 № ХЭГ/802
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт ☞ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245008743

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлд:

“6.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 32.10-д “Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын анхдугаар хуралдаанаас хурлын даргыг 4 жилийн хугацаагаар сонгоно. Хурлын дарга хуралдааныг удирдах, хуралдааны тэмдэглэл, шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэл хангах үүрэгтэй ажиллах бөгөөд хурлын даргад баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх урамшуулал олгоно” гэж заасан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.9-д “Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл нь ... гагцхүү иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дараагийн хуралдаанд бэлтгэх, хуралдааныг товлон зарлах үүрэгтэй. Зөвлөлийн хурлыг Хуралдааны дарга тэргүүлнэ” гэж заасантай зөрчилдөж байна.

Мөн хурлын даргад баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх урамшуулал олгохоор тусгасан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.11-д “Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргад ажилласан хугацааны урамшууллыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс олгож болно.” гэж заасантай агуулгын хувьд давхцаж байна.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдлын үед авах шуурхай арга хэмжээ, иргэдэд үзүүлэх яаралтай туслалцаа, худалдаа, үйлчилгээ, нийтийн тээвэр, ундны ус, бэлчээр ашиглалт, хамгаалалт зэрэг хүн амын тулгамдсан асуудал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас урьдчилан эрх олгосон бусад асуудлаар шийдвэр гаргаж, дараагийн хуралд танилцуулах”-аар тусгасан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 51.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн

бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.” гэж заасантай зөрчилдөж байна.

Мөн Зөвлөлийн шийдвэрлэхээр тусгасан асуудал нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 58, 59, 60, 61 дүгээр зүйлд заасан аймаг, сум, баг, хорооны Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамаарч байгаагийн зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах суурь зарчимд нийцэхгүй байна.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна.” гэж заасан бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг зөвхөн тухайн шатны Хурал хэрэгжүүлэх болохыг анхаарах шаардлагатай.

3.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56.4.1 дэх заалтыг “Хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой байхаар” нэр дэвшигчид тавигдах шаардлагыг өөрчлөхөөр тусгажээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56.4.1 дэх заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр уг заалтын “Тайлбар” хэсэгт заасан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах болон тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх урьдчилсан нөхцөл хангагдаагүй байна.

Түүнчлэн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх төрийн удирдлагад нэр дэвшигчид харилцан адилгүй шаардлага тогтоох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг хөндөж болзошгүй байна.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-д заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж заасны дагуу орон нутаг дахь улс төрийн зүй бус аливаа үйл ажиллагаанаас сэргийлэх зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45.6-д “Улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эвсэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.” гэсэн зохицуулалтыг тусган хуульчилсан бөгөөд 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр уг хэсгийн Тайлбарт заасан.

Иймд хуулийн төслийн 5 дугаар зүйлд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45.6 дахь хэсгийг хүчингүй болгохоор тусгасан үндэслэл нь тодорхойгүй, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах болон тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх урьдчилсан нөхцөл хангагдаагүй байна.

5.Хуулийн төсөл болон хуулийн төслийн үзэл баримтлал нь Хууль тогтоомжийн тухай хуулиар тавигдах бүтэц, хэлбэр, эх бичвэрийн агуулгын нийтлэг


шаардлагыг хангаагүй, дэлгэрэнгүй танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайланг хавсаргаагүй байгааг анхаарах.

6.Төсвийн тухай хуулийн 6.2.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх” гэж заасан ба хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт ачаалал үзүүлэхээр байгаа нь дунд хугацаанд төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй байх Засгийн газрын зарчим, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд бүх шатны төсөвт байгууллага хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх, аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх, зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах замаар төсвийг хэмнэхээр заасантай зөрчилдөж байна.

Түүнчлэн, Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа бөгөөд Засаг даргын үндсэн цалинг нэмэгдүүлэх тохиолдолд баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын даргад олгох урамшууллын хэмжээ мөн нэмэгдэхээр байгааг анхаарах.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
ХУУЛЬ САНААЧЛАГЧ**



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ГАНБОЛД**

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, уг хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид булаан авч хурлыг хэлбэрийн төдий болгож байгаа гэсэн үндэслэлээр энэ бүтцийг хүчингүй болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг байгуулсан. Ингэснээр өдөр тутмын тулгамдсан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байнга хуралдуулах шаардлага гарч, тийм боломжгүйгээс орон нутагт зохицуулах шаардлагатай ажлууд цалгардах, хугацаа алдах нөхцөл үүсч байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу ажиллаж байгаа хэдий ч тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй байгаа тул Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж уг хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл” гэсэн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан.

Ингэснээр Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Засаг дарга, түүнийг томилох гэсэн 56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалтад баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь заавал дээд боловсролтой байх шаардлага тавьж байгаа нь амьдралд нийцэхгүй бөгөөд дээд боловсролтой боловсон хүчин орон нутагт хүрэлцээгүй байгаа учир бүрэн дундаас доошгүй боловсролтой байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Багийн иргэдийн Нийтийн Хуралдаан даргалагчид зохих туршлага, бэлтгэлтэй боловсон хүчин шаардлагатай байгааг харгалзан хуралдааны даргыг 4 жилийн хугацаагаар сонгож, байнгын ажиллагаатай байхаар, мөн зохих урамшуулал олгохоор хуулийн төслийг боловсрууллаа.

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 4 зүйлтэй. Төслийн 1 дүгээр зүйлээр цахим болон технологийн бусад хэлбэрээр хуралдаанд оролцсоныг хурлын ирцэд оруулан тооцох, мөн 2 дугаар зүйлээр "... аймгийн төв, 20 мянгаас дээш хүн ам бүхий хот, суурин газрын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 50 өрх тутмаас" нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэнээр хуралдааныг хүчинтэйд тооцох зохицуулалтыг нэмж тусган, 3 дугаар зүйлээр баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгох бөгөөд хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж ажиллах, хуралдаан даргалагчид баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх урамшуулал олгох, мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд зарим эрх олгож, хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой иргэнийг сонгох зэрэг өөрчлөлтүүдийг оруулж, 4 дүгээр зүйлээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо нь "Улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эсвэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй" гэсэн зохицуулалтуудыг тус тус хүчингүй болгосон.

Гурав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар:

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд:

Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүй бөгөөд дагалдах хууль батлахгүй.

ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн талаар

Нэг. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, уг хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид булаан авч хурлыг хэлбэрийн төдий болгож байгаа гэсэн үндэслэлээр энэ бүтцийг хүчингүй болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг байгуулсан. Ингэснээр өдөр тутмын тулгамдсан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байнга хуралдуулах шаардлага гарч, тийм боломжгүйгээс орон нутагт зохицуулах шаардлагатай ажлууд цалгардах, хугацаа алдах нөхцөл үүсч байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу ажиллаж байгаа хэдий ч тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй байгаа тул Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж уг хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл” гэсэн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан. Ингэснээр Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Засаг дарга, түүнийг томилох гэсэн 56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалтад баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь заавал дээд боловсролтой байх шаардлага тавьж байгаа нь амьдралд нийцэхгүй бөгөөд дээд боловсролтой боловсон хүчин орон нутагт хүрэлцээгүй байгаа учир бүрэн дундаас доошгүй боловсролтой байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Багийн иргэдийн Нийтийн Хуралдаан даргалагчид зохих туршлага, бэлтгэлтэй боловсон хүчин шаардлагатай байгааг харгалзан хуралдааны даргыг 4 жилийн хугацаагаар сонгож, байнгын ажиллагаатай байхаар, мөн зохих урамшуулал олгохоор хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн талаар

Нэг. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, уг хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид булаан авч хурлыг хэлбэрийн төдий болгож байгаа гэсэн үндэслэлээр энэ бүтцийг хүчингүй болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг байгуулсан. Ингэснээр өдөр тутмын тулгамдсан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байнга хуралдуулах шаардлага гарч, тийм боломжгүйгээс орон нутагт зохицуулах шаардлагатай ажлууд цалгардах, хугацаа алдах нөхцөл үүсч байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу ажиллаж байгаа хэдий ч тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй байгаа тул Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж уг хуулийн "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл" гэсэн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан. Ингэснээр Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Засаг дарга, түүнийг томилох гэсэн 56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалтад баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь заавал дээд боловсролтой байх шаардлага тавьж байгаа нь амьдралд нийцэхгүй бөгөөд дээд боловсролтой боловсон хүчин орон нутагт хүрэлцээгүй байгаа учир бүрэн дундаас доошгүй боловсролтой байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Багийн иргэдийн Нийтийн Хурлын даргад зохих туршлага, бэлтгэлтэй боловсон хүчин шаардлагатай байгааг харгалзан хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгож, байнгын ажиллагаатай байхаар, мөн зохих урамшуулал олгохоор хуулийн төслийг боловсрууллаа.

Хоёр. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Монгол Улсын Засгийн газраас санал авахад 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар тэргүүлэгчдийн үүргийг өөрчлөн хуралд шилжүүлэх үзэл баримтлалын чиглэлтэй зөрчилдсөн, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх төрийн удирдлагад нэр дэвшигчдэд харилцан адилгүй шаардлага тогтоосон, Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн шаардлага зөрчсөн зэрэг үндэслэлээр эсрэг санал ирүүлжээ.

Засгийн газрын байр суурийг хүлээн авч байна. Гэвч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах хэрэгцээ, шаардлага байна.

2.1.Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.

2.2.Хуулийн шаардлагад нийцсэн боловсон хүчин орон нутагт төдийлөн хангалттай биш байгаа зэрэг болно.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтэд 2018, 2023 онд хийсэн дүн шинжилгээний тайланд орон нутгийн газар зүй, цаг үеийн ажлын онцлогтой уялдан нийтийн төлөөлөгчийн хурлын эрх мэдлийг “Хурлын дарга хороодод шилжүүлэхийг одоохондоо түдгэлзэж, эхлээд Зөвлөлд эрх шилжүүлэх зохицуулалтыг тодорхой хугацаанд туршиж зүгшрүүлэх хэрэгтэй” /2023 он, 63-р тал/ гэж зөвлөснийг анхааралдаа авлаа. Ингэхдээ “Хурлаас шилжүүлснээс бусад тохиолдолд Хурлын бүхэн эрхэд хамаарах асуудлаар бие даасан шийдвэр гаргахгүй” гэсэн хязгаарлалт хийж байгаа юм.

Гурав.Баг нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу өөрийн нутаг дэвсгэртэй, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж байх шаардлага бий. /Дүн шинжилгээ 2018 он, 21-р тал/ Үүнд тодорхой бэлтгэл шаардлагатай тул түр орхин багийн иргэдийн Нийтийн Хурлын ирцийг хангахын тулд томоохон багийн өрхийн төлөөллийн тоог өөрчлөх, түүнчлэн цахим хэлбэрээр саналаа өгөх боломжийг тодорхой болгох шаардлагатай байгаа юм.

2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 21 аймгийн төвийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, ажлын албаныхантай хийсэн зөвлөгөөнөөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хэрэгжилтийг хэлэлцүүлж, саналыг нэгтгэхэд дараах чиглэл гарч байв.

3.1.Сумын өрх, хүн амын бодит статистик тоон үзүүлэлт, тэдэнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний агуулга, хүртээмж, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн хамаарч сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хотын Захирагчийн албаны орон тооны бүтэц, хязгаарыг тогтоодог болох;

Өөрөөр хэлбэл 1000 гаруйхан хүн амтай, 40 000 хүн амтай сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тамгын газрын бүтэц, орон тоо адилхан байгаагаас нэг төрийн албан хаагчид ногдох ачаалал зөрүүтэй байгааг харгалзан ялангуяа Засаг даргын Тамгын газар, хотын Захирагчийн албаны бүтэц, орон тоог нэг бүрчилсэн байдлаар тогтоодог болох.

Мөн эдгээр сумдын ИТХ-ын Ажлын албыг хүн амын тоо, тэдгээрээс сонгогдсон төлөөлөгчдийн тоотой уялдуулан бусад сумдаас өөр тогтоодог байх. Нутгийн өөрөө удирдах байгууллага аймгийн түвшинд 16 хүртэл орон тоотой ажиллаж, аймгийн төвийн суманд ТЗ, ТҮ-д хамаарах 3 /Хурлын дарга, жолооч орохгүйгээр/ орон тоотой ажиллаж байгаа нь бодлогын түвшинд өөр өөр байх ч “Орон нутгийн зэрэглэлтэй хот” бодлого боловсруулж байгаа газар юм.

3.2.Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд аймгийн төвийн ойролцоо оршдог, хүн ам цөөнтэй, жижиг нутаг дэвсгэртэй, зэргэлдээ сумын төвүүд нь хэт ойрхон байдаг сумдыг бүсчлэн хөгжүүлэх замаар нэгтгэн зохион байгуулах;

3.3.“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт бүсчилсэн хөгжилд суурилан хэрэгжүүлэх, ялангуяа хот, суурин газрын хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Гэвч Улсын Их Хурлын энэ удаагийн бүрэн эрхийн хугацаа дуусах дөхөж байгаа, сонгуулийн компани ажил эхлэх гэж байгааг харгалзан юуны өмнө өөрчлөх шаардлагатай тулгамдсан цөөн асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулсан, иргэд олон нийтээс санал ирээгүй болно.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ
ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.13 дахь хэсэг нэмсүгэй:

1/32 дугаар зүйлийн 32.13 дахь хэсэг:

“32.13.Цахимаар болон техник, технологийн бусад хэлбэрээр хуралдаанд оролцсон бол хурлын ирцэд оруулан тооцож болно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсгийн “20 өрх тутмаас” гэсний дараа “, аймгийн төв, 20 мянгаас дээш хүн ам бүхий хот, суурин газрын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 50 өрх тутмаас” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/32 дугаар зүйлийн 32.10 дахь хэсэг:

“32.10.Баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй. Хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.”

Тайлбар:-Энэ хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2/51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг:

“51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь дараах асуудлаар шийдвэр гаргаж, дараагийн хуралдаанд танилцуулж болно.

51.2.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авах шуурхай арга хэмжээ;

51.2.2.нийтийн эрүүл мэнд, тээвэр, ундны ус, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт зэрэг хүн амын тулгамдсан асуудал;

51.2.3.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас урьдчилан эрх олгосон бусад асуудал;

51.2.4.энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.”

3/56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалт:

“56.4.1.хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой;”

4 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйл, 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН
НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

2024 он

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

НЭГ. Ерөнхий мэдээлэл

2020 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг бий болгосон. Шинэчилсэн найруулгын 51 дүгээр зүйлд зааснаар “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий 5-7 хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.” гэж, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт зааснаар ИТХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байхаар зохицуулсан.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлүүд үйл ажиллагаагаа МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгад заасны дагуу хэвийн явуулж байгаа хэдий ч энэхүү шинэ бүтэц нь тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй учраас Хурлын хороодоос төдийлөн ялгарахгүй, давхардсан бүтэц болж байгаа талаар орон нутгаас тавьж буй шүүмжлэл нь бодит үндэслэлтэй гэж үзсэн байна.

Улсын Их Хурлаас Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталсан бөгөөд орон нутагт дагаж мөрдөж байгаа боловч өдөр тутмын тулгамдсан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байнга хуралдуулах шаардлага гарч, тийм боломжгүйгээс орон нутагт зохицуулах шаардлагатай ажлууд цалгардах, хугацаа алдах нөхцөл үүсч байгаа тул Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгох нь нь зүйтэй гэж үзэж уг хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл” гэсэн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан. Ингэснээр Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.

Багийн иргэдийн Нийтийн Хурлын даргад зохих туршлага, бэлтгэлтэй боловсон хүчин шаардлагатай байгааг харгалзан хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгож, байнгын ажиллагаатай байхаар, мөн зохих урамшуулал олгох нь зүйтэй, мөн баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь заавал дээд боловсролтой байх шаардлага тавьж байгаа нь амьдралд нийцэхгүй бөгөөд дээд боловсролтой боловсон хүчин орон нутагт хүрэлцээгүй байгаа учир бүрэн дундаас доошгүй боловсролтой байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн байна.

ХОЁР. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Мөн чанар, цар хүрээг тогтоох

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын зарим зүйл, заалтын хэрэгжилтийн талаар

2023 онд хийгдсэн судалгаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн талаарх зохицуулалтыг сайжруулах шаардлага үүсээд байгааг онцлон дурдаад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зарим бүрэн эрхээ Зөвлөлд шилжүүлдэг байх боломжийг хуулиар нээж өгөх хувилбарыг судалсан байна.

Тус судалгаанд дурдагдсанаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн талаар хамгийн олон давтагдан гарсан санал, шүүмжлэл нь:

- Зөвлөл шийдвэр гаргах эрх мэдэлгүй байна;
- Зөвлөл Хурлын хороодоор нэгэнт хэлэлцсэн асуудлыг давхардуулан хэлэлцэх нь цаг дэмий үрж, Хурлын ажлын албанд илүү ачаалал үүсгэж, үр ашиг багатай байна;
- Зөвлөл шийдвэр гаргадаггүй учраас төлөөлөгчид Зөвлөлд орж ажиллах сонирхолгүй, орсон ч яваандаа залхаж байна;
- шинэчилсэн найруулгад заасан "хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах" чиг үүргээ хэрэгжүүлэхэд Зөвлөл хүчгүйдэж байна;
- Зөвлөл өмнө нь байсан "тэргүүлэгчид" шиг ажиллахгүй учраас Хурлын хуралдаанаар том, жижиг нийлсэн маш олон асуудал хэлэлцэх болдог, үүнээс болж хуралдааны чанар суларч байна. Уг нь хуралдаанд оролцож байгаа төлөөлөгчдийн үнэтэй цагийг стратегийн шинжтэй гол гол асуудлаа тал бүрээс нь хэлэлцэхэд зориулбал Хурлын ач холбогдол дээшилнэ;
- "Тэргүүлэгчид" байхгүй учраас хуулийн хугацаатай олон асуудал шийдэгдэхгүй хүлээгдэх, мөн Хурлын байгууллага "ажилгүй" сул зогсож байгаа мэт сэтгэгдэл иргэдэд төрж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэхэд дараахь зорилгыг тодорхойллоо:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар онлайн болон бусад технологийн дэвшил ашиглах хэлбэрээр оролцсоныг хурлын ирцэд оруулан тооцохоор хуульд нэмж тусгах, Баг хорооны Иргэдийн нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгож, хуралдаан даргалагч хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй ажиллана, хуралдаан даргалагчид баг хорооны даргын цалингийн 50 хувьтай тэнцэх урамшуулал олгох өөрчлөлтийг тусган, иргэдийн хурлын зөвлөлд зарим эрх олгох, хорооны засаг даргад дээд, багийн засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой иргэнийг сонгох, иргэдийн нийтийн Хурлын ирц бүрдүүлэлтэд нэмэлт оруулах, "улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эсвэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй" гэсэн зохицуулалтыг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татахтай холбоотой зохицуулалтыг тус тус хассан

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбаруудын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулья.

- “Тэг” хувилбар буюу зохицуулалт хийхээс татгалзах”- Шинэчилсэн найруулгын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа хэдий ч тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй тул Хурлын хороодоос төдийлөн ялгарахгүй, давхардсан бүтэц болж байгаа бөгөөд хуулиар тодорхой зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байгаа учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.
- “Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх”-тохиромжгүй хувилбар.
- “Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх”-тохиромжгүй хувилбар
- “Төрөөс санхүүгийн интервенц хийх”-тохиромжгүй хувилбар.
- “Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх” – Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагад тодорхой чиг үүргийг шилжүүлэх боломжгүй.
- “Захиргааны шийдвэр гаргах”-тохиромжгүй хувилбар.
- “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах”- Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах, иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцох нөхцлийг бүрдүүлэх, Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагааг хангах зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэ асуудлыг шийдвэрлэх боломж байгаа тул энэ хувилбарыг сонгов.

Үүнд:

1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу ажиллаж байгаа хэдий ч тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй байгаа тул Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгох нь нь зүйтэй гэж үзэж, зарим нэг эрх мэдлийг зөвлөлд шилжүүлэхээр хуулийн төсөл боловсруулсан. Ингэснээр Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм.

2.Баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь заавал дээд боловсролтой байх шаардлага тавьж байгаа нь амьдралд нийцэхгүй бөгөөд дээд боловсролтой боловсон хүчин орон нутагт хүрэлцээгүй байгаа учир хорооны Засаг дарга дээд

боловсролтой, багийн Засаг дарга бүрэн дундаас доошгүй боловсролтой байх өөрчлөлт оруулах юм.

3.Багийн иргэдийн Нийтийн Хуралдаан даргалагчид зохих туршлага, бэлтгэлтэй боловсон хүчин шаардлагатай байгааг харгалзан хуралдааны даргыг 4 жилийн хугацаагаар сонгож, байнгын ажиллагаатай байхаар, мөн зохих урамшуулал олгохоор хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд хугацаа гарахад алдахгүй байх, мөн Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.

ТАВ. СОНГОСОН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн хууль тус бүрээр гаргалаа.

Хүснэгт 1.

Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх		Үгүй	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх		Үгүй	
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх		Үгүй	
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл		Үгүй	

	хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх			
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/		Үгүй	

4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх			Хамаарахгүй
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх			Хамаарахгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх			Хамаарахгүй

Хүснэгт 2.

Эдийн засгийн үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үү?	Үгүй	
	1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/?	Үгүй	
	1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах уу?		
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1 Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах уу?	Үгүй	
	2.2 Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох уу?	Үгүй	
	2.3 Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох уу?	Үгүй	
	2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох уу?	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон	3.1 Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал	Үгүй	

захиргааны зардал	үүсэх эсэх			
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4 Бараа, бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч буй захиргааны зардлын ачаалал	4.1 Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардлуудыг /Жишээ нь, мэдээлэх, тайлан гаргах гэх мэт/ бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1 Өмчлөх эрхийг /үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3 Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг зөрчсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци ба судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх			Хамаарахгүй
	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх			Хамаарахгүй

7.Хэрэглэгч ба гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн төвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.4 Хувь хүний /гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд, мөн урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2 Тодорхой бүс нутгуудад тодорхой чиглэлд, ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3 Жижиг, дунд үйлдвэрүүд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад онцгой нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3 Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
10.Микро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	
	10.3 Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	

11.Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
------------------------	--	------	--	--

Хүснэгт 3.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		Ажлын байрны давхардал, хийдэл байхгүй болж, ажлын чанарт эерэгээр нөлөөлнө
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.4 Шинээр ажлын стандарт гаргаж ирэх эсэх		Үгүй	
	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг бий болгох эсэх		Үгүй	
	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал		Үгүй	

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	үүсгэх эсэх			
	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүдэд, үндэстний цөөнхөд г.м		Үгүй	
	3.3 Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2 Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		/эерэгээр/
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1 Хувь хүний /нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ/-т нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Төрийн үйлчилгээ сайжирна

6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.2 Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3 Иргэдийн боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5 Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.2 Хэл соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3 Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцлийг

бүрдүүлэх бөгөөд орон нутагт боловсон хүчний нөөц төдийлөн хангалттай биш байгааг харгалзан багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой хүнийг томилуулах хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Баг нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу өөрийн нутаг дэвсгэртэй, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж байх шаардлагатай бөгөөд багийн нийтийн хурлын ирцийг хангахын тул томоохон багийн өрхийн төлөөллийн тоог өөрчлөх тэрчлэн онлайн, цахим хэлбэрээр саналаа өгөх боломжийг тодорхой болгох нь зүйтэй байгаа юм.

Цаашид сумын өрх, хүн амын бодит статистик тоон үзүүлэлт, тэдэнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний агуулга, хүртээмж, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн хамаарч сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хотын Захирагчийн албаны орон тооны бүтэц, хязгаарыг тогтоодог болох зэрэг нэлээдгүй олон чухал асуудлууд байгаа юм.

Гэвч Улсын Их Хурлын энэ удаагын бүрэн эрхийн хугацаа дөхөж байгаа, сонгуулийн компани ажил эхлэх гэж байгааг харгалзан юуны өмнө өөрчлөх шаардлагатай цөөн асуудлуудыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж дүгнэж байна.

ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Гадаад улс орнуудын туршлагыг үзэхэд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага эрх мэдлээ шилжүүлэх нь ердийн үзэгдэл байдаг. Харин дараах хэд хэдэн хязгаарлалтыг тавьдаг байна. Өөрөөр хэлбэл, дараах бүрэн эрхээ шилжүүлэхийг хориглодог:

- хувь хэмжээ тогтоох;
- хэм хэмжээ тогтоосон акт батлах;
- мөнгө зээлэх, эсхүл урт хугацааны бодлогод тусгагдаагүй хөрөнгө худалдан авах, захиран зарцуулах;
- урт хугацааны бодлого, жилийн төлөвлөгөө, жилийн тайлан батлах;
- Засаг даргыг томилох, чөлөөлөх;
- цалин, урамшуулал тогтоох.

НАЙМ.ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэн дараахь зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн ба дагаж өөрчлөгдөх хууль тогтоомж байхгүй байна.

Хоёр.Хууль батлагдсантай холбогдуулан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэх татах тухай” журмыг Улсын Их Хурлаас батлах шаардлагагүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Монгол Улсын Үндсэн хууль (1992 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга) (2020 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилт. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл. 2023 он.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төсөл. 2019 он.
- Монгол Улсын статистикийн эмхэтгэл - 2022. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо.
- Governance manual - Delegation of decision-making functions and powers. aucklandcouncil.govt.nz
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн цахим хуудас. <http://khural.mn/dashboard/tuluulugch>
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо. <https://m-election.mn>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn/mn>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn>

1.

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”-
ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ**

2024.05.13

Улаанбаатар хот

УДИРТГАЛ

Энэхүү зардлын тайлангийн зорилго нь “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд зайлшгүй гаргах зардлыг тооцоход оршино.

Хуулийн төсөлд Баг хорооны Иргэдийн нийтийн хуралдааны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахаар дараах үндсэн заалтуудыг тусгасан. Үүнд:

1. Баг хорооны Иргэдийн нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй ажиллана, хуралдаан даргалагчид баг хорооны даргын цалингийн 50.0 хувьтай тэнцэх урамшуулал олгоно.”
2. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргад ажилласан хугацааны урамшууллыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс олгож болно.

Хуулийн төслийн хэрэгжилтийн явцад гарах зардлын тооцоог Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д тусгасны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, эрх зүйн зохицуулалтад хамаарах төрийн байгууллагын зардлын ангиллаар тооцон боловсрууллаа.

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дундажаар 40.0 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Энэ хүрээнд төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ шинэчлэгдэж, албан тушаалын хамгийн бага цалингийн хэмжээг 1.0 сая төгрөгт хүргэсэн. Үүнтэй уялдуулан баг хороо, сум дүүрэг, аймаг нийслэлийн Засаг дарга, түүний орлогчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоож, багийн Засаг даргын үндсэн цалинг 1,250.0 мянга, хорооны Засаг даргын үндсэн цалинг 1,400.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн. Түүнчлэн 2024 оны 04 дүгээр сарын 1-ний өдрөөс дахин 10.0 хувиар нэмэгдүүлж, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралтаар багийн Засаг даргын үндсэн цалинг 1,375.0 мянган төгрөгөөр, хорооны Засаг даргын үндсэн цалин 1,540.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1851 баг, хороо үйл ажиллагаа явуулж байгааг харгалзан түүнийг багийн болон хорооны Засаг даргын үндсэн цалингийн дунджаар, гарсан үр дүнг 12-оор тус тус үржүүлэхэд Баг хорооны Иргэдийн нийтийн хурлын хуралдааны даргалагчийн нэг жилийн үндсэн цалин 32,373.9 сая төгрөг гарч байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг баталсан. Тус хавсралтад төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын төрийн алба хаасан хугацаанаас хамаарч 1.0-25.0 хувийн нэмэгдэл авах талаар заасан. Нэмэгдлийн дундаж хувийг 13.0 гэж үзэн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргад ажилласан хугацааны урамшууллыг тооцно гэвэл урамшууллын нийт дундаж зардал улсын хэмжээнд $32,373.9 \times 0.13 = 4,208.6$ сая төгрөг болж байна.

Нийт дүнгээр нь авч үзвэл Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргад нэг жилд 36,582.6 сая төгрөгийн цалин урамшууллыг улсын хэмжээнд олгохоор байна.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг хэрэгжүүлснээр гарах зардлын тооцооллын үр дүн болж байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ
ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү үнэлгээг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл /цаашид “Хуулийн төсөл” гэх/-д Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.3-т заасан хуульд өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан хувилбар байв. Хуулийн төсөл нь 4 зүйлээс бүрдэж байгаа.

Иймээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төсөлд бүхэлд нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлээ.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь хуульд нэмэлт оруулах төсөл тул түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс үнэлэхийг зорьж сонголоо.

“Хүлээн зөвшөөрөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл тусгайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хуульд нэмэлт оруулах төсөл тул хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд болон хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцсэн эсэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид булаан авч хурлыг хэлбэрийн төдий болгож байгаа гэсэн үндэслэлээр энэ бүтцийг хүчингүй болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг байгуулсан. Ингэснээр өдөр тутмын тулгамдсан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байнга хуралдуулах шаардлага гарч, тийм боломжгүйгээс орон нутагт зохицуулах шаардлагатай ажлууд цалгардах, хугацаа алдах нөхцөл үүсч байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд үнэлгээ хийхээр сонгож авлаа.

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.6¹ дэх хэсэг нэмсүгэй:

1/32 дугаар зүйлийн 32.6¹ дэх хэсэг:

“32.6¹.цахимаар болон техник, технологийн бусад хэлбэрээр оролцсон бол хурлын ирцэд оруулан тооцож болно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсгийн “20 өрх тутмаас” гэсний дараа “, аймгийн төв, 20 мянгаас дээш хүн ам бүхий хот, суурин газрын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 50 өрх тутмаас” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/32 дугаар зүйлийн 32.10 дахь хэсэг:

“32.10.Баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах,

дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй. Хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.”

Тайлбар:-Энэ хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2/51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг:

“51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь дараах асуудлаар шийдвэр гаргаж, дараагийн хуралдаанд танилцуулж болно.

51.2.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авах шуурхай арга хэмжээ;

51.2.2.нийтийн эрүүл мэнд, тээвэр, ундны ус, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт зэрэг хүн амын тулгамдсан асуудал;

51.2.3.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас урьдчилан эрх олгосон бусад асуудал;

51.2.4.энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.”

3/56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалт:

“56.4.1.хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой;”

4 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйл, 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсгийг тайлбарын хамт хүчингүй болсонд тооцсугай.

“**Ойлгомжтой байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

/Хуулийн төсөл 4 зүйлтэй./

“**Харилцан уялдаа**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

/Хуулийн төсөл 4 зүйлтэй./

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой</u> байдлыг шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид булаан авч хурлыг хэлбэрийн төдий болгож байгаа гэсэн үндэслэлээр энэ бүтцийг хүчингүй болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг байгуулсан. Ингэснээр өдөр тутмын тулгамдсан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байнга хуралдуулах шаардлага гарч, тийм боломжгүйгээс орон нутагт зохицуулах шаардлагатай ажлууд цалгардах, хугацаа алдах нөхцөл үүсч байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу ажиллаж байгаа хэдий ч тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй байгаа тул Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж уг хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл” гэсэн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан. Ингэснээр Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Засаг дарга, түүнийг томилох гэсэн 56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалтад баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь заавал дээд боловсролтой байх шаардлага тавьж байгаа нь амьдралд нийцэхгүй бөгөөд дээд боловсролтой боловсон хүчин орон нутагт хүрэлцээгүй байгаа учир бүрэн дундаас доошгүй боловсролтой байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Багийн иргэдийн Нийтийн Хуралдаан даргалагчид зохих туршлага, бэлтгэлтэй боловсон хүчин шаардлагатай байгааг харгалзан хуралдааны даргыг 4 жилийн хугацаагаар сонгож, байнгын ажиллагаатай байхаар, мөн зохих урамшуулал олгохоор хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, орон нутгийн чухал шийдвэрүүд гарахад хугацаа алдахгүй байх, мөн Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.

29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлага хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараахь стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуульд оруулж байгаа нэмэлт нь хуулийн зорилттой нийцэж байгаа харилцааг зохицуулахад оршино.
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.

7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул шаардлагагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл, Төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох материал;

5.2.Дүгнэлт

Хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон

зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан.

Харилцан уялдаатай байдлыг хангасан.

5.3.Зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж холбогдох зөвлөмжийг хууль санаачлагчид өгсөн болно.

-----oO-----



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ИТХ-ЫН ЗӨВЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ АСУУДАЛ БОЛОН
АЙМГИЙН ТӨВИЙН ХҮН АМ БА СОНГОГДОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ТООНЫ ХАРЬЦААНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА

Мэдээлэл лавлагаа
Судалгааны код: СТ-24/407

2024.03.19

Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Ганболд
Хянасан: ПССХ-ийн захирал Ц.Цогзолмаа
Судалгаа удирдсан: ПССХ-ийн Ахлах зөвлөх Б.Үүрцайх (Ph.D)
Судлаачид: Г.Билгээ, Э.Дашзэгвэ, Ц.Ариунаа, Э.Билгүүн, П.Уранчимэг

УЛААНБААТАР
2024 ОН

ИТХ-ЫН ЗӨВЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ АСУУДАЛ БОЛОН АЙМГИЙН ТӨВИЙН ХҮН АМ БА СОНГОГДОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТООНЫ ХАРЬЦААНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА

Судалгааны захиалгын дагуу "ИТХ-ын Зөвлөлтэй холбоотой зарим асуудал болон аймгийн төвийн хүн ам, сонгогчдын тоо ба аймгийн төвөөс сонгогдох ИТХ-ын төлөөлөгчийн тооны харьцааны талаарх мэдээлэл лавлагаа"-г Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс гүйцэтгэв.

Судалгааны захиалгын даалгавар:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхийг татан буулгаснаар хэлэлцэх асуудал бүрээр иргэдийн хурлыг цуглуулж хуралдуулах зэргээр учирч байгаа хүндрэл бэрхшээл, санал, гомдлыг тоймлож хийсэн дүгнэлт;

2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг хурлын чөлөөт цагаар бие даасан шийдвэр гаргаж, түүнийгээ хуралдаанд танилцуулдаг байхаар тэдэнд Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор олгож байсан урамшуулал олгоход улсын хэмжээгээр улс, орон нутгийн төсвөөс гарах зардлын хэмжээ;

3. Багийн иргэдийн Нийтийн Хурлын даргыг 4 жилийн хугацаагаар сонгож дээрх Засгийн газрын тогтоолын дагуу урамшууллыг олгоход улс болон орон нутгийн төсвөөс гарах зардлын хэмжээ;

4. Аймгийн төвийн хүн амаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төлөөлөгч сонгох зохистой хувь хэмжээ.

**Нэг. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний
удирдлагын тухай хуулийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлтэй
холбоотой зарим заалтын хэрэгжилт**

Өмнөх туршлага:

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө тус хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) болон иргэдийн Нийтийн Хурал (ИНХ)-ын хуралдааны чөлөө цагт нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг түүний Тэргүүлэгчид гүйцэтгэнэ" хэмээн заасан байсан.

2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (ЗЗНДНТУТХ) (2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс хүчингүй болсон)-ийн 9 дүгээр зүйлд зааснаар Хурлын Тэргүүлэгчид нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцооны нэг хэсэг байх бөгөөд Хурлын хуралдааны чөлөө цагт бүрэн эрхийг нь Тэргүүлэгчид хэрэгжүүлдэг байсан. Энэ нь жилд 1-2 удаа болдог хуралдааны завсар хооронд Хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн байна. Гэхдээ Үндсэн хууль, ЗЗНДНТУТХ-ийн аль алинд нь Тэргүүлэгчийг сонгох шалгуурыг тодорхойлоогүй. ЗЗНДНТУТХ-ийн 20 дугаар зүйлээр Хурлын Тэргүүлэгчийн бүрэн эрхийг тусгайлан заасны дээр өмч, газар эзэмших, ашиглах, үнэ, тариф тогтоох, Хурлын шийдвэрийг хүчингүй болгох гэх мэт Хурлын өөрийнх нь олон чухал эрх мэдлийг Тэргүүлэгчдэд шилжүүлжээ. Хурлын Тэргүүлэгчдийн тоо нийслэл, аймагт 7-11, сум, дүүрэгт 5-7, баг, хороонд 3-5 байсан. Энэ нь цөөн тооны эрх мэдэл бүхий хүмүүс Хурлын өмнөөс шийдвэр гаргах бололцоог олгож байв. Тухайлбал, баг байгуулах, түүний нутаг дэвсгэрийн заагийг тогтоох, ашигт малтмал хайх, олборлохтой холбоотой асуудал шийдвэрлэх зэрэг нутгийн өөрөө удирдах байгууллагын амин чухал асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчид шийдэх болсон байна (Сэлэнгэ, Булган, Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрүүдийг судалж үзэхэд). Мөн түүнчлэн иргэд сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан орон нутгийнхаа үйл хэрэгт оролцох, төлөөллөө хэрэгжүүлэх зарчим алдагдахад хүрч байсан.¹

Өнөөгийн байдал:

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр энэхүү "Тэргүүлэгчид" гэсэн бүтцээс татгалзсан. 2020 онд батлагдсан МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгаар ИТХ-ын Зөвлөлийг бий болгосон.

Шинэчилсэн найруулгын 51 дүгээр зүйлд зааснаар "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий 5-7 хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ." Шинэчилсэн найруулгын 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт зааснаар ИТХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

ИТХ-ын Зөвлөлүүд үйл ажиллагаагаа МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгад заасны дагуу хэвийн явуулж байгаа хэдий ч энэхүү шинэ бүтэц нь тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй учраас Хурлын хороодоос төдийлөн ялгарахгүй, давхардсан бүтэц болж байгаа талаар орон нутгаас тавьж буй шүүмжлэл нь бодит үндэслэлтэй гэж үзэж байна. УИХ-аас Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталсан ба орон нутагт дагаж мөрдөж байна.²

¹ ЗНДНТУТХ-ийн хэрэгжилтийн байдал хийсэн дүн шинжилгээ, 2019 он.

² ЗНДНТУТХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилт, 2023 он.

Тулгамдсан асуудал:

2023 онд хийгдсэн шинэчилсэн найруулгын зарим зүйл, заалтын хэрэгжилтийн судалгаанд ИТХ-ын Зөвлөлийн талаарх зохицуулалтыг сайжруулах шаардлага үүсээд байгааг онцлон дурдаад ИТХ-аас зарим бүрэн эрхээ Зөвлөлд шилжүүлдэг байх боломжийг хуулиар нээж өгөх хувилбарыг судалсан байна.

Тус судалгаанд дурдагдсанаар ИТХ-ын Зөвлөлийн талаар хамгийн олон давтагдан гарсан санал, шүүмжлэлээс чухлыг нь тоймловол:

- Зөвлөл шийдвэр гаргах эрх мэдэлгүй байна;
- Зөвлөл Хурлын хороодоор нэгэнт хэлэлцсэн асуудлыг давхардуулан хэлэлцэх нь цаг дэмий үрж, Хурлын ажлын албанд илүү ачаалал үүсгэж, үр ашиг багатай байна;
- Зөвлөл шийдвэр гаргадаггүй учраас төлөөлөгчид Зөвлөлд орж ажиллах сонирхолгүй, орсон ч яваандаа залхаж байна;
- шинэчилсэн найруулгад заасан "хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах" чиг үүргээ хэрэгжүүлэхэд Зөвлөл хүчгүйдэж байна;
- Зөвлөл өмнө нь байсан "тэргүүлэгчид" шиг ажиллахгүй учраас Хурлын хуралдаанаар том, жижиг нийлсэн маш олон асуудал хэлэлцэх болдог, үүнээс болж хуралдааны чанар суларч байна. Уг нь хуралдаанд оролцож байгаа төлөөлөгчдийн үнэтэй цагийг стратегийн шинжтэй гол гол асуудлаа тал бүрээс нь хэлэлцэхэд зориулбал Хурлын ач холбогдол дээшилнэ;
- "Тэргүүлэгчид" байхгүй учраас хуулийн хугацаатай олон асуудал шийдэгдэхгүй хүлээгдэх, мөн Хурлын байгууллага "ажилгүй" сул зогсож байгаа мэт сэтгэгдэл иргэдэд төрж байна.

"Тэргүүлэгчид" байхгүй болсон нь дан ганц сөрөг үр дагавар авчирсан гэвэл бас өрөөсгөл болно. Хууль тогтоогчийн зүгээс "төлөөлөгч бүр бүрэн эрхээ хариуцлагатай хэрэгжүүлж, Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болно" гэсэн хүлээлт эхний үр дүнгээ өгч байгааг орон нутгийн төлөөллүүд онцолж байсан. Хурлын хороодын үйл ажиллагаа идэвхжиж, төлөөлөгчид өөрсдийгөө орон нутгийн чухал шийдвэр гаргагч нар гэдгээ ойлгож эхэлж байна. Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгосноор, нэг талаас Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх боловч нөгөө талаас, Хурал бүрэн эрхээ "цөөхөн хэдэн хүнд" даатган орхидог хуучин практик сэргэж болзошгүй юм. Иймд Хурал эрх шилжүүлэхдээ энэ хоёр хүчин зүйлийн тэнцвэрийг олж ажиллах шаардлага үүснэ.

Гадаад улс орнуудын туршлагыг үзэхэд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага эрх мэдлээ шилжүүлэх нь ердийн үзэгдэл байдаг. Харин дараах хэд хэдэн хязгаарлалтыг тавьдаг байна.³ Өөрөөр хэлбэл, дараах бүрэн эрхээ шилжүүлэхийг хориглодог:

- хувь хэмжээ тогтоох;
- хэм хэмжээ тогтоосон акт батлах;
- мөнгө зээлэх, эсхүл урт хугацааны бодлогод тусгагдаагүй хөрөнгө худалдан авах, захиран зарцуулах;
- урт хугацааны бодлого, жилийн төлөвлөгөө, жилийн тайлан батлах;
- Засаг даргыг томилох, чөлөөлөх;
- цалин, урамшуулал тогтоох.

³ Governance manual - Delegation of decision-making functions and powers. aucklandcouncil.govt.nz

Энд санал болгож буй “Зөвлөлд Хурлын зарим эрхийг шилжүүлдэг болох зохицуулалт хийх” шийдлийн талаар асуумжийн аргаар аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн байр суурийг судлахад 2000 гаруй төлөөлөгч хариулт өгсөн байна. Тодруулбал;

“Хороодын үйл ажиллагаа болон Зөвлөлийн үйл ажиллагаа нь хоорондоо давхцаж байна гэж та үзэж байна уу?” гэсэн асуултад 2,003 оролцогч хариулснаас 54,7% нь “Үгүй”, 45,3 хувь нь “Тийм” гэж хариулжээ.

Дээрх асуултын хариултыг бататгах зорилгоор **“ИТХ хуульд заасан зарим бүрэн эрхээ худалдааны чөлөөт цагт өөр этгээдэд шилжүүлэх замаар хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай юу?”** гэж өөрөөр томъёолж асуусан байна. Асуултад 2,011 оролцогч хариулснаас 57,0% нь “Үгүй”, 43,0 хувь нь “Тийм” гэж хариулжээ.

Эндээс харахад, судлаачийн санал болгож буй шийдэл төлөөлөгчдийн 43-45 хувийн дэмжлэгийг авсан байна. Санал ийнхүү хуваагдсан байдал нь, нэг талаас, Хурлын бүрэн эрхийг бусад этгээдэд шилжүүлэх хувилбар төдийлөн сайн дэмжлэг авахгүй байгааг харуулж байгаа ч, нөгөө талаас, эсрэг санал өгсөн төлөөлөгчид Хурлын эрх мэдлийг өөр этгээдэд алдахгүй гэсэн байр суурьтай байгааг илтгэж байгаа үр дүн юм. Энэ бол мөн чухал зэрэг үр дүн юм. Төлөөлөгчид өмнө нь “тэргүүлэгчид”-эд эрх мэдлээ даатган орхидог байсан хуучин практикийг аль болох дахин сэргээхгүй байх сонирхолтой байна гэж ойлгож болно. Харин дэмжиж санал өгсөн төлөөлөгчид Хурлын тасралтгүй үйл ажиллагааг чухалчилсан гэж тайлбарлаж болно.

Дээрх хоёр асуулттай холбоотойгоор дараах асуултыг оролцогчдоос асуусан: **“Дээрх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон тохиолдолд Хурал зарим бүрэн эрхээ аль этгээдэд шилжүүлэх боломжтой гэж үзэж байна вэ?”** гэсэн асуултад 1,799 оролцогч хариулснаас 44,6% нь Хурлын Зөвлөлд, 24,7% нь Хурлын хороодод, 20,8% нь Хурлын даргад гэж хариулжээ. Эндээс үзэхэд, эрх шилжүүлэхийг дэмжигчдийн хувьд энэ гурван нийлбэр гэж үзвэл 96,1%-д хүрч байна. Зөвхөн хэнд буюу ямар субъектэд гэдгээрээ хуваагдаж байгаа боловч бүгд дэмжиж байгаа хэрэг юм.

1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэгт “Хурлын хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга нь шийдвэрлэх” зохицуулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны хуулиар өөрчлөлт оруулсан байна. Энэ бол “тэргүүлэгчид” байхгүй болсонтой холбоотойгоор асуудлыг цаг алдахгүй, түргэн шуурхай шийдэж байх үүднээс Хурлын даргад эрх мэдэл олгосон хэрэг ажээ. Хурлын Зөвлөлд эрх шилжүүлэх зохицуулалт бий болсон тохиолдолд энэ нэмэлт, өөрчлөлтийг эргэж харах нь зүйтэй болно.

2023 онд хийгдсэн шинэчилсэн найруулгын зарим зүйл, заалтын хэрэгжилтийн судалгаанд дурдсанаар Хурлын дарга, Хурлын хороодод эрх шилжүүлэхийг одоохондоо түдгэлзэх нь зүйтэй бөгөөд эхлээд Зөвлөлд эрх шилжүүлэх зохицуулалтыг тодорхой хугацаанд туршиж, зүгшрүүлэх хэрэгтэй гэж үзсэн байна.

Дурдагдсан судалгаанд МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын бусад хуульд тогтоомжид харшлах зүйл, заалт бий эсэхийг судалсан байна. Захиргааны Ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно.” гэж заасан байдаг. Эндээс үзэхэд, шинэ хуульд болон бусад хууль тогтоомжид заасан Хурлын бүрэн эрхийг шилжүүлж болох эсэхийг тухай бүр зөвшөөрсөн заалт тусгаж өгөх шаардлагатай. Зөвшөөрөөгүй бол хориглосон гэж үзнэ.

Санал:

2023 онд хийгдсэн шинэчилсэн найруулгын зарим зүйл, заалтын хэрэгжилтийн судалгаанд МУЗЗНДНТУтХ-ийн шинэчилсэн найруулгын 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт дараах байдлаар өөрчлөн найруулах саналыг өгсөн байна:

“51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлаас эрх шилжүүлснээс бусад тохиолдолд Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.”

Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын зардлын тооцоо

ИТХ-аас Зөвлөлдөө эрх шилжүүлэх замаар хуралдааны чөлөө цагт Хурлын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх боломжтой болсон тохиолдолд Хурлын Зөвлөлийн гишүүдийн ажиллах хэвийн нөхцөлөөр хангах, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээнд тодорхой зардал гаргах шаардлагатай болно. Иймд Монгол Улсын нийслэл, 21 аймаг, 9 дүүрэг, 330 сумын ИТХ-ын Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын нэг жилийн зардлын тооцоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

№	Засаг захиргааны нэгж	Нэгжийн нийт тоо	Зардлын жишиг (жилээр) (Засгийн газрын 2021 оны 402-р тогтоол)	Хурлын зөвлөлийн гишүүдийн тоо (дээд хягзаараар)	Дүн (сая ₮-өөр)
1.	Нийслэл	1	15.0	7	105.0
2.	Дүүрэг	9	3.0	7	189.0
3.	Аймаг	21	5.0	7	735.0
4.	Сум	330	1.0	7	2 310.0
Нийт дүн					3 339.0

Тайлбар: зардлын тооцоог гаргахдаа Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2022-д дурдсан тоо баримтыг үндэслэн Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын хэвсралт “Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг”-ийг удирдлага болгов.

Гурав. Баг, хорооны ИНХ-ын дарга нарт олгох урамшууллын зардлын тооцоо

Баг, хорооны ИНХ-ын даргыг 4 жилийн хугацаагаар сонгож ажиллуулсан тохиолдолд гарах нэг жилийн урамшууллын зардлыг дээр дурдсан зардлын нийтлэг жишгийг баримтлан тооцлоо. Ингэхдээ багийн ИНХ-ын даргын урамшууллыг сумын төлөөлөгчийн, хорооны ИНХ-ын даргын урамшууллыг дүүргийн төлөөлөгчийн зардлын жишгээр тус тус тооцсон болно.

Хүснэгт 2.

№	Засаг захиргааны нэгж	Нэгжийн нийт тоо	Зардлын жишиг (жилээр) (Засгийн газрын 2021 оны 402-р тогтоол)	Хурлын зөвлөлийн гишүүдийн тоо (дээд хягзаараар)	Дүн (сая ₮-өөр)
1.	Хороо	204	3.0	7	4 284.0
2.	Баг	1645	1.0	7	11 515.0
Нийт дүн					15 799.0

Дөрөв. Аймгийн төвийн хүн ам ба аймгийн төвөөс сонгогдох ИТХ-ын төлөөлөгчийн тооны харьцаа

Аймгийн төвийн хүн ам ба аймгийн төвөөс сонгогдох ИТХ-ын төлөөлөгчийн тооны харьцааны статистик мэдээг дараах эх сурвалжийн хүрээнд бэлтгэв. Үүнд:

- Хүн амын тоог Үндэсний статистикийн хорооны 2023 оны тайлан мэдээ (аймгийн нийт хүн амын тоог Жилийн дундаж хүн амын тоо, аймгийн төвийн хүн амын тоог Монгол Улсад оршин суугаа жилийн дундаж хүн амын тоо);
- сонгогчдын тоог Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын 2023 оны статистик мэдээ;
- төлөөлөгчдийн тоог Сонгуулийн Ерөнхий Хорооны ИТХ-ын сонгуулийн 2016-2020 оны дүнгээс тус тус авч ашиглалаа.

Хүснэгт 3.

№	Аймгийн нэр	Аймгийн төвийн сумын нэр	Хүн амын тоо (2023 оны байдлаар ҮСХ)		Сонгогчдын тоо		Төлөөлөгчдийн тоо		
			Аймаг (жилийн дундаж хүн амын тоо)	Аймгийн төв (МУ-д оршин суугаа жилийн дундаж хүн амын тоо)	Аймаг (УБЕГ 2023)	Аймгийн төв (УБЕГ 2023)	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн тоо (2016-2020)	Аймгийн төвийн сумаас сонгогдсон АИТХ-ын төлөөлөгчийн тоо (2016-2020)	Аймгийн төвийн сумын ИТХ-ын төлөөлөгчийн тоо (2020 он, ҮСХ)
1	Архангай	Эрдэнэбулган	92,746	21,595	60,971	13,967	39	10	31
2	Баян-Өлгий	Өлгий	115,696	40,764	69,241	26,431	39	13	31
3	Баянхонгор	Баянхонгор	88,282	32,750	56,393	20,497	41	16	31
4	Булган	Булган	60,848	12,664	40,759	8,613	33	6	31
5	Говь-Алтай	Есөнбулаг	56,925	18,955	37,447	12,142	41	16	31
6	Говьсүмбэр	Сүмбэр	18,024	13,218	11,058	8,168	17	13	31
7	Дархан-Уул	Дархан	108,584	87,509	70,224	59,193	33	27	31
8	Дорноговь	Сайншанд	71,323	28,146	45,553	17,596	31	14	31
9	Дорнод	Хэрлэн	83,879	47,394	52,914	29,377	35	22	21
10	Дундговь	Сайнцагаан	46,239	16,829	30,466	10,573	35	11	31
11	Завхан	Улиастай	71,462	16,332	46,839	10,718	41	12	31

12	Орхон	Баян-Өндөр	109,783	102,395	71,262	68,786	35	31	31
13	Өвөрхангай	Арвайхээр	114,796	36,254	74,950	22,753	41	12	31
14	Өмнөговь	Даланзадгад	74,067	30,623	47,799	19,778	33	12	31
15	Сүхбаатар	Баруун-Урт	65,455	24,135	41,679	14,790	33	15	31
16	Сэлэнгэ	Сүхбаатар	107,016	21,716	71,335	15,256	37	8	31
17	Төв	Зуунмод	91,745	17,215	62,531	11,965	41	6	31
18	Увс	Улаангом	83,939	33,474	52,503	20,724	41	16	31
19	Ховд	Жаргалант	91,264	33,172	56,652	21,063	41	17	31
20	Хөвсгөл	Мөрөн	136,739	42,883	88,381	27,478	41	14	31
21	Хэнтий	Хэрлэн	79,026	24,394	51,419	15,549	39	16	21

Аймгийн төвийн хүн ам ба аймгийн төвөөс сонгогдох ИТХ-ын төлөөлөгчийн тооны харьцааны хувьд, нийт улсын хэмжээнд нэг төлөөлөгчид дунджаар 2221 хүн ногдож байна.

Хамгийн өндөр нь Орхон аймгийн нэг төлөөлөгчид 3303 хүн, хамгийн бага нь Говьсүмбэр аймгийн нэг төлөөлөгчид 1185 хүн тус тус ногдож байна.

Хүснэгт 4.

№	Аймгийн нэр	Аймгийн төвийн сумын нэр	Аймгийн төвийн хүн ам ба төлөөлөгчийн тооны харьцаа
1	Орхон	Баян-Өндөр	3303
2	Дархан-Уул	Дархан	3241
3	Баян-Өлгий	Өлгий	3136
4	Хөвсгөл	Мөрөн	3063
5	Өвөрхангай	Арвайхээр	3021
6	Төв	Зуунмод	2869
7	Сэлэнгэ	Сүхбаатар	2715
8	Өмнөговь	Даланзадгад	2582
9	Архангай	Эрдэнэбулган	2180
10	Дорнод	Хэрлэн	2154
11	Булган	Булган	2111
12	Увс	Улаангом	2092
13	Баянхонгор	Баянхонгор	2047
14	Дорноговь	Сайншанд	2010
15	Ховд	Жаргалант	1951
16	Сүхбаатар	Баруун-Урт	1809
17	Дундговь	Сайнцагаан	1730
18	Хэнтий	Хэрлэн	1525
19	Завхан	Улиастай	1361
20	Говь-Алтай	Есөнбулаг	1185
21	Говьсүмбэр	Сүмбэр	1017

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Монгол Улсын Үндсэн хууль (1992 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга) (2020 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилт. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй "Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь" төсөл. 2023 он.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй "Монгол Улсад төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь" төсөл. 2019 он.
- Монгол Улсын статистикийн эмхэтгэл - 2022. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо.
- Governance manual - Delegation of decision-making functions and powers. aucklandcouncil.govt.nz
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн цахим хуудас. <http://khural.mn/dashboard/tuluulugch>
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо. <https://m-election.mn>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn/mn>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn>



Хууль санаачлагч



Гочоогийн
ГАНБОЛД

Өргөн баригдсан

Хэлэлцэх эсэх

Аж.



✓ Дагах

БОЛОВСРУУЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ТӨСЛИЙН
МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 ОНЫ 3-Р САРЫН 21 ӨДӨР

УЛААНБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА НУТАГ
ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол улсын засаг захиргаа,
нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
хуулийн 32 дугаар зүйлд доор дурьдсан
агуулгатай 32.61 дэх хэсэг нэмсүгэй:

